

Сарын урьдчилсан төлөв

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- о **Баруун** (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- о **Төв** (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул)
- о **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- о **Говь** (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "бүх нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.


Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон "Хиймэл оюун ухаан, тоон загварчлал, судалгааны хэлтэс"-ээс тодруулах боломжтой.

Уур амьсгалын тойм

Аравдугаар сарын агаарын температурын ОЖД нь Баян–Өлгий, Хөвсгөл, Завханы ихэнх, Увс, Ховдын зарим газар, Архангайн зүүн, Төвийн зүүн хойд, Баянхонгорын хойд, Хэнтийн баруун хойд хэсгээр -12...-20°C, Говь–Алтай, Баянхонгор, Дундговийн өмнөд, Өмнөговийн нутаг, Дорноговийн ихэнх хэсгээр -8...-2°C, бусад нутгаар -8...-12°C дулаан байдаг байна (**Зураг 1**). Харин олон жилийн явцын хувьд арваннэгдүгээр сарын агаарын дундаж температур 1979, 1981, 1984–1987, 1989, 1993, 1996, 2000, 2002–2003, 2009, 2011–2012, 2015–2016, 2023 онуудад ОЖД–аас 1–5°C–аар хүйтэн байсан бол 1980, 1983, 1988, 1994–1995, 1998–1999, 2001, 2005–2008, 2010, 2013–2014, 2020–2021, 2022, 2024 онуудад ОЖД–аас 1–3°C–аар дулаан байсан байна (**Зураг 2**).




Зураг 1. 11-р сарын агаарын температурын ОЖД, [$^{\circ}\text{C}$].




Зураг 2. 11-р сарын агаарын температурын олон жилийн явц

[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 4–8 мм, Алтайн өвөр говь болон говийн аймгуудын нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–4 мм цас ордог байна (**Зураг 3**). Монгол орны хэмжээнд аравдугаар сарын нийлбэр хур тунадас 1979, 1987, 1990, 1992, 1996, 2000, 2003, 2009–2012, 2015–2016, 2023 онуудад олон жилийн дунджаас ахиу, 1985, 1988–1989, 1995, 1997, 1999, 2004–2008, 2014, 2018, 2021, 2022, 2024 онуудад ОЖД–аас харьцангуй бага хур тунадас орсон байна (**Зураг 4**).



Зураг 3. 11–р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм]



Зураг 4. 11–р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц

[Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ


Баруун аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур ихэнх нутгаар ОЖД–ийн орчим, харин Завханы ихэнх, Баянхонгорын хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн (**Зураг 5**), хур тунадас ихэнх нутгаар ОЖД–ийн орчим, Завханы хойд болон зүүн, Баянхонгорын хойд хэсгээр ахиу байх төлөвтэй байна (**Зураг 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 7**)–д харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар ОЖД-аас дулаан, цаашдаа хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн сүүлч үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас 1-2°C дулаан, харин нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас 1-3°C хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим байх төлөвтэй байна. Хур тунадас сарын ихээр уулархаг нутгаар, хоёр болон гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар цас орж, салхи ширүүсэн, цасан болон шороон шуурга шуурч болзошгүй байна.

Төвийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас хүйтэн (**Зураг 5**), хур тунадас ихэнх нутгаар ОЖД–аас ахиу байх төлөвтэй байна (**Зураг 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 8**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн сүүлч үеүдэд ихэнх нутгаар ОЖД-аас 1-2°C дулаан, харин нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд болон гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас 1-3°C хүйтэн байх төлөвтэй байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн эхээр уулрхаг нутгаар, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд зарим газраар, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав

хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар цас орж, салхи ширүүсэн цасан шуурга шуурч болзошгүй байна.


Зүүн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас хүйтэн (**Зураг 5**), хур тунадас Хэнтий, Дорнодын хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 9**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлч үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас $1-2^{\circ}\text{C}$ дулаан, харин хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд болон гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ОЖД–аас $1-3^{\circ}\text{C}$ хүйтэн байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн сүүл, хоёрдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар цас орж, зарим газраар цасан шуурга шуурч болзошгүй байна.

Говийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Өмнөговийн баруун хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас бага зэрэг хүйтэн (**Зураг 5**), хур тунадас Өмнөговийн зүүн, Дорноговийн ихэнх хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим (**Зураг 6**) байх төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 10**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн сүүлч үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас $1-3^{\circ}\text{C}$ дулаан, харин хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд ОЖД–аас $1-3^{\circ}\text{C}$ хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим байна. Хур тунадас хоёрдугаар арав хоногийн дунд үед зарим газраар цас орж, зарим үед салхи ширүүсэн шороон шуурга шуурч болзошгүй байна.




Зураг 5. 2025 оны 11-р сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв, °C

[Х-агаарын температур ОЖД-аас хүйтэн, Н-агаарын температур ОЖД-ийн орчим]



Зураг 6. 2025 оны 11-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан төлөв, мм


[И-хур тунадас ОЖД-аас ахиу, Н-хур тунадас ОЖД-ийн орчим, Б-хур тунадас ОЖД-аас бага]



Зураг 7. Баруун аймгуудын нутгийн 2025 оны 11–р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,


үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 8. Төвийн аймгуудын нутгийн 2025 оны 11–р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,


үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 9. Зүүн аймгуудын нутгийн 2025 оны 11–р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,

үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 10. Говийн аймгуудын нутгийн 2025 оны 11-р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,

үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]

ЗӨВЛӨМЖ

Энэ сард агаарын дундаж температур төв, зүүн, говийн аймгуудын нутгаар олон жилийн дунджаас хүйтэн, хур тунадас нутгийн хойд хэсгээр ахиу байх төлөвтэй байна. Нэгдүгээр арав хоногийн эхэн үед ихэнх нутгаар ОЖД-аас дулаан байх боловч нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд ОЖД-аас хүйтэн, хур тунадастай байх төлөвтэй байгаа тул хол замд гарахдаа богино хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээг цаг тухай бүрт авч ашиглан, ажлаа төлөвлөхийг зөвлөж байна.